

## АМЖИЛТЫГ ЦОГЦЛООХ НЬ АНУ-ЫН ШИНЭ ЗАСГИЙН БОЛОМЖ\*

*АНУ-ын дэд Ерөнхийлөгч Жозеф Байден*

*АНУ-ын шинэ засаг урьд хожид байгаагүй, өөрөөр хэлбэл Хүйтэн дайн, 9-р сарын 11-ний халдлагын дараах он жилүүдээс ч илүү адармаатай цаг үед АНУ-ын гадаад бодлогын жолоог атгах болж байна. Энэ аюул, сорилтын үл харгалзан нөгөөгэйгүүр 2009 оны 1-р сараас үүрэгт ажлаа эхлүүлсэн Барак Обамагийн засаглалаас илүү хүчирхэг, аюулгүй ирээдүйг бүтээх цаг үе бидний өмнө байна. Эх орондоо болоод хилийн чанадад бид бүхний авч хэрэгжүүлсэн үйл хэрэг хөрөнгө оруулалтын үр дүнд АНУ дэлхийн давуу хүчээ хадгалах дараагийн 10 жил биднийг хүлээж байна. Миний бие олон нийтийн харилцах албанд ажилласан 40 жил дотор Америкийн ирээдүйд ийм их итгэл дүүрэн байснаа санахгүй юм. Гэхдээ бид тэргүүлэх гүрний статусаа үргэлжлүүлэн хадгалж гэмээнэ миний энэхүү итгэл найдвар биеллээ олох учиртай.*

### **Хүчний суурь**

АНУ-ын дэлхийн манлайлал юуны түрүүнд бидний динамик эдийн засаг, цэрэг зэвсгийн хүчин чадал, олон талт үнэ цэнэд оршино гэдэг итгэл үнэмшил дор АНУ-ын үе үеийн засаг бодлого үйл ажиллагаагаа хэрэгжүүлсээр ирсэн. Улмаар хамтын ажиллагаа, түншлэлийн холбоо харилцаагаа өргөжүүлэн, орчин үеийн хэв маягт нийцүүлж, олон улсын дэг журамд шигтгэх замаар энэхүү гол хүч давуу талаа бий болгож өнөөг хүрсэн билээ.

Эдийн засгийн уналтад ороод байсан тэр цаг үед манай засгийн нэн тэргүүнд ханцуй шамлан орсон ажил бол эдийн засгийг хүнд хэцүү нөхцөлөөс гаргах явдал байлаа. Ингэхийн тулд хувийн бизнес, их сургуулиудын шилдэг судалгаа шинжилгээний ажил, хууль журмыг дэмжих замаар дэлхийн хамгийн хүчирхэг, шинэчлэлд суурилсан эдийн засгийг дахин босгож чадсан юм. Ухаалаг хөрөнгө оруулалт, Америк арга ухааны хүчээр АНУ сэргээгдэх эрчим хүч, нүүрсний салбарт дэлхийн эрчим хүчний хувьсгалын түүчээ болсон юм.

Мөн эдийн засаг дахин сэргэсний үр дүнг дараах байдлаар харж болно. Ажлын байрны тогтвортой өсөлт, гадаад эх үүсвэрээс дотоод руу шилжсэн шилжилт цаашилбал АНУ дахин бизнесийн хөрөнгө оруулалтын хамгийн таатай бүс болсныг А.Т.Кеарнеу-с гаргадаг гадаад шууд хөрөнгө оруулалтын таатай газар жагсаалтыг сүүлийн 4 жил тэргүүлсэн үр дүнгээс харж болохоор байна.

Ийм чадамжтай эдийн засаг нь манай цэрэг зэвсгийн хүчинд нэн чухал хүчин зүйл. Бид цаашдаа жагсаалтын дараагийн 8 улсыг нийлүүлснээс илүү их төсвийг батлан хамгаалах салбартаа тусгадаг тэрхүү өрсөлдөгчийнхөө урд нь алхсаар байх болно. Бидэнд дэлхийн түүхэн дэх хамгийн хүчирхэг явган хүчний анги болон дэлхийн аль ч өнцгөөс ирэх агаарын болоод усан цэргийн хүчнийг илрүүлэх чадвар байна. АНУ-ын тусгай үүрэг гүйцэтгэгч хүчийг дэмжих, цахим орон зайг

\* МУИС-ийн ОУХНУС-ийн магистрант Т.Түвшинзаяа орчуулав

хангах, шинэ техник технологи, автомат системийн салбарт хөрөнгө оруулахад хүчин чармайлт гарздах шаардлагагүйгээр бэлтгэгдсэн төдийгүй цаашдаа ч энэ чигээ хадгалах бүрэн бололцоотой.

Энэ бол манай улсын батлах хамгаалах салбарын үечилсэн хамгаалалтын нэгээхэн хэсэг юм. Жишээлбэл лазер хамгаалалтын тусламжтайгаар хилийн аюулгүй байдлыг бэхжүүлж, усан боомтууд дээрх хяналт аюулгүй байдлыг үйл ажиллагааг сайжруулж, онгоцны буудлууд дээрх дэлгэцээр хянах процедурыг бэхжүүлж байна. Манай тагнуул, хууль хэрэгжүүлэгч албаны мэргэжилтэнгүүд халдлага үйлдэхээр завдаж байх магадлалтай үй олон хүмүүсийн араас мөрдөж, дотоодын болоодын гадаадын өнцөг булан бүрт байгаа мэргэжилтэнгүүдтэй хамтран ажиллах замаар тухайн нөхцөлд байдалд тохирсон түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна. АНУ-ын тусламжтайгаар, манай түнш улс орнууд, иргэний эрхийг хамгаалахын зэрэгцээ аюулгүй байдлын хангах хүрээнд зорчигчийн мэдээлэл солилцох зэргээр харилцан мэдээлэл солилцож байна.

Бас нэгэн бодит жишээ дурьдвал, Америкийн хамгийн том хүч бол бидний хүчний жишээ биш харин бидний олон улсад үзүүлж буй үлгэр жишээ хүч юм. Юу юунаас илүү, биднийг бусад хүчнээс ялгаруулдаг нэг зүйл бол хүлээцтэй байдал болоод АНУ-ын язгуур үнэ цэнэд тууштай үнэнч ханддаг явдал юм. Америкийн дараагийн үе бидний 7 жил хагасын хугацаанд хүний язгуур эрхийг хамгаалах хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаар (цагаачлалын системийг илүү гэгээлэг энэрэнгүй болгоход уриалсан, эмэгтэйчүүдэд олгогдох боломж бололцоог тэлсэн, ижил хүйстний эрхийн асуудлыг дотооддоо төдийгүй гадаадад хамгаалсан) бахархана гэдэгт эргэлзэх зүйл алга. Энэ нь зүгээр л хийх ёстой зөв зүйл төдийгүй зөв стратеги юм учир нь бидний зөв зүйлийг хамгаалах хүрээнд хийж буй ажил хэрэг бусдыг ч мөн адил зөв зүйлийн төлөө тэмцэхэд нөлөөлдөг билээ. Бидний холбоотон түнш улсууд (Ази Европ дахь ардчилсан тогтолцоот улс орнуудаас авхуулаад Африк, Латин Америк, Дундад ази дахь түнш улсууд) бидний удирдах манлайлах чадварыг хэд дахин нэмэгдүүлж өгдөг тул бидний хувьд энэ маягаар бусдыг зөв зүйлийн төлөө босоход уриалах нь чухал юм. Исламын улс эбола, цаг уурын өөрчлөлт зэрэг томоохон сорилтуудыг даван туулахад яг дээрх аргаар бид хамтын үйл хэрэгт уриалдаг юм.

Цагаа олсон зөв шүүмжлэл бидэнд Өнгөрсөн зуун дахь АНУ-ын хөгжил дэвшилд хүрэхэд түлхэц болсон тэрхүү цаг үедээ нийцсэн бодлогын хэрэгжилтээс үлгэр жишээ авах, нээлттэй олон улсын тогтолцоог бэхжүүлэхэд үр дүнгээ өгсөөр ирсэн билээ. Дэлхийн 2-р дайны дараах олон улсын дэг журмын гол ханыг АНУ босголцож энэ цагаас хойш дэлхий дахинд энэ жишиг тогтжээ. Тийм ч учраас бид зэвсэглэлийг үл дэлгэрүүлэх гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж, цөмийн зэвсэг материалыг үгүй хийх дэлхий дахины үйл ажиллагаанд тэргүүн эгнээнд хүчин зүтгэж улмаар худалдааг хөгжүүлэх тэлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, далайн болоод кибер орчны шинэ тутам гарч буй сорилтод чиглэсэн шинэ бодлого нормыг дэвшүүлэхэд товчхондоо дэлхийн дэг журмыг хамгаалах өргөжүүлэх хүрээнд хүч хөлс эрч хүчээ зориулдаг юм.

Тиймдээ ч XXI зуунд дэлхийг манлайлах, удирдах, чиглүүлэхэд АНУ-аас илүү гарах улс байхгүй биз. Гэхдээ энэ бол бидний дэлхийд гүйцэтгэх шаардлагатай үүрэг роль болохоос хувиршгүй байнгын үүрэг роль биш гэдгийг санууштай. Хэрвээ дараагийн засаг энэхүү ойлголтыг эсрэгээр нь ойлговоос бидний өнгөрсөн 7 жил хагас ч гэлтгүй бүхэлдээ өнгөрсөн 70 жилийн хугацаанд их хүчин чармайлтаар бий болсон үйл хэрэг талаар болох болно. Хэдийгээр дараагийн шинэ ерөнхийлөгч үй олон асуудлуудтай нүүр тулах нь лавтай ч ерөнхийд нь 4 ангилж болох юм. Үүнд: Номхон далайн хоёр талд ижил боломж олгох, бүс нутгийн их гүрнүүдтэй харилцах харилцааг зохицуулах, үндэстэн дамнасан асуудлуудад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх, хэт даврагч бүлэглэлийг дарах зэрэг болно.

### ***Номхон далайн бүс дэх боломж бололцоо***

Дараагийн ерөнхийлөгч дэлхийн хамгийн динамик бүс болох Номхон далайн хоёр талд ижил бололцоо олгох хүрээнд явуулах АНУ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй бөгөөд үүнийг бөмцөрцгийн баруун талаас эхлүүлэх нь зүйтэй. Канад, Латин Америк, Карибын тэнгис нь манай дотоодын аюулгүй байдал хөгжил дэвшилд томоохон нөлөөтэй бөгөөд XXI зуунд баруун бөмбөрцгийн улс орнууд манай гадаад бодлогын тэргүүн эгнээд багтах учиртай.

Энэхүү бүс нутагт дахин анхаарлаа хандуулснаар ямар үр дүн гарч болохыг бид бэлхнээ харсан. Ерөнхийлөгч Обамагийн засаглал хөрш орнуудтайгаа харилцах харилцаагаа сайжруулах зорилтын хүрээнд хийгдсэн ажлуудын (Куба-д үүл хаалгаа нээсэн г.м) үр дүнд АНУ-ын нэр хүнд энэ бүс нутагт урьд хожид байгаагүй их өсөлтийг үзүүлсэн билээ. Тиймээс дараагийн засаг Америкийн бүх ард түмний аюулгүй байдал, хөгжил дэвшлийг бэхжүүлэхэд энэхүү ажлыг хөшүүрэг болгох хэрэгтэй. Хийх зүйлс гэвэл Канад, Мексиктэй харилцаа сайжруулах, Аргентинтай шинэ тогтоосон харилцаагаа бэхжүүлэх, Төв Америк дахь үйл ажиллагаагаа тогтворжуулах, бүс нутгийн их гүрнүүд болох Бразил, Чили, Колумбтай түншийн харилцаагаа тэлэх бичиг баримтгүй цагаачлагчид, хар тамхины наймаа, авилгал хээл хахууль, ардчиллын сул тогтолцоо зэрэг асуудлууд бидний өмнө сорилт хэвээр үлдэх нь тодорхой ч өнөөгийн бүс нутгийн байдлыг хямрал гэхээсээ илүүтэй боломж бололцоогоор тодорхойлж болохоор байна. Тэдгээр боломж бололцоо нь худалдаа хөрөнгө оруулалтыг хүчирхэгжүүлэх, эрчим хүчний интеграци, удаан хугацаанд зөрчилдөөнтэй байдлыг эцэслэснээс илүү энх тайван орчныг бүрдүүлэх зэргээр тодорхойлогдож байна. Мэдээж түүхэнд анх удаа Канадын хойд хэсгээс Чилийн өмнө үзүүр хүртэлх газар нутгийг дундаж давхарга бүхий ардчилсан аюулгүй бүс нутаг хэмээн төсөөлөх боломж бүрдэж байна.

Номхон далайн нөгөө талд бид Азитай хамтран явуулах үйл ажиллагаа дахин цэцэглэсэн. Урьд хожид байгаагүйгээр их хүчирхэгжсэн улс орнууд болох Өмнөд Солонгос, Австрали, Филиппин, Японтой байгуулсан холбоотны гэрээг дараагийн засаг цаашид үргэлжлүүлэн мөрдөх болно. Азийн аюулгүй байдлыг хангагч гол хүчин байх нь үнэгүй олддог завшаан биш гэдэг нь яах аргагүй үнэн. Гэхдээ Ази тивд зөрчил мөргөөн үүссэнээс үүдэн АНУ-ын ард түмэнд учирч болох эдийн засгийн зардлыг бид хэзээ ч дутуу үнэлж болохгүй.

Дараагийн засаг бидний гол холбоотон улсуудаас гадна бусад улс орнуудтай харилцах холбоо харилцаагаа үргэлжлүүлэн тэлэх өргөжүүлэх улмаар Хятадтай харилцаагаа хөгжүүлэх, Вьетнамтай харилцаа холбоогоо гүнзгийрүүлэх, Энэтхэгтэй стратегийн түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх, дүрэм журмыг хөгжүүлэх өргөжүүлэх хүрээнд Зүүн Азийн үндэстний ассоциаттай хамтран ажиллах зэрэг ажлуудыг хариуцан ажиллах нь.

Дэлхийн хүн амын тал хувь, дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй зах зээлийн олонхи нь оршин байдаг энэ бүс нутаг дахь эдийн засгийн боломж бололцоог тоохгүй өнгөрч болохгүй юм. Тиймээс Номхон далайн бүс нутгийн түншлэлийн аюулгүй байдлыг хангах тухай асуудал манай засгийн газрын тэргүүн зорилтод багтдаг. Транс-Номхон далайн түншлэлийн холбооны 12 улс дэлхийн худалдааны 30 хувь, дэлхийн ДНБ-ий 40 хувийг, дэлхийн эдийн засгийн өсөлтийн 50 хувийг эзэлдэг байна. АНУ-ын энэ бүс нутаг дахь манлайллын ач тусаар холбогдох гэрээ хэлэлцээрт ажилчдын эрх, ажиллах орчин, оюуны өмчийг дэмжих олон улсын стандартыг өсгөх заалтуудыг багтаасан байдаг. Энэ хууль дүрэм үгүй бол энэ бүс нутагт стандарт доогуур, сул бүтэцтэй тийм гэрээ хэлэлцээрүүд газар авах байсан биз ээ. Энэ хэлэлцээр эдийн засгаас гадна геополитикийн шинж чанартай. Жишээлбэл Хятадын Өмнөд тэнгисийн аюулгүй байдал, Зүүн Хойд Ази дахь цөм зэвсгийг үл дэлгэрүүлэх зэрэг асуудлын хүрээнд гэрээ боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх асуудалд АНУ удирдах чиглүүлэх хэрэгтэй, эс бөгөөс энэ бүс нутаг болоод манай улсын хооронд сул орон зай үүсч улмаар үүнийг нөхөх гэж хошуурах өрсөлдөгчид бидэнд бий гэдгийг санууштай.

### ***Бүс нутгийн их гүрнүүдтэй харилцах харилцааг зохицуулах***

Бараг дэлхийн бүх хэсэгт, олон улсын дэг журам бүрэлдэн тогтоход томоохон нөлөө бүхий бүс нутгийн их гүрнүүдтэй АНУ нүүр тулдаг. Ихэнх нь Америкийн сонгосон замыг дагадаг. Хятадтай харилцах харилцаанаас илүү үнэн үгүй, АНУ, Хятад дэлхийн хоёр том эдийн засаг гэдэг жишмээр бидний хувь заяа гарцаагүй огтлолцсон. Ерөнхийлөгч Обама болон миний бие энэхүү харилцааг дэвшилтэт хамтын ажиллагаа, хариуцлагатай өрсөлдөөнөөр тодорхойлохыг зорьсон юм. Бид Бээжингийн засгийн газартай ижил өөрсдийн зарим нэгэн байр суурийг олж харж улмаар эрх чөлөө, оюуны өмч, цаг уурын өөрчлөлт зэрэг дэлхий дахины өмнө тулгараад буй асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд тодорхой түүхэн өөрчлөлт хийсэн. Түүнчлэн манай хоёр улс хүний эрх, оюуны өмч зэрэг асуудлуудын төлөө хамтдаа бат зогссон билээ.

Оросын жишээн дээр яг үүнтэй адилаар нэг талаас тактикийн хамтын ажиллагаа, стратегийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ нөгөө талаас тогтоон барих бодлогоо үргэлжлүүлэн явуулах хэрэгтэй. Крымийг хууль бусаар нэгтгэх гэсэн Оросын оролдлого, зүүн Украин дахь түрэмгийллийн шинжтэй үйл ажиллагаа үргэлжилсэн хэвээр байгаа нь Европ дахь хөрш улс орнуудын халдашгүй дархан байх тухай Хүйтэн дайны дараах журмын тулгуур зарчмыг зөрчсөн хэрэг болсон билээ. Үүний хариуд, зөрчил мөргөлдөөн дуусгавар болсныг батлах Минскийн

гэрээний заалтыг ОХУ бүрэн гүйцэт мөрдөх хүртэл энэхүү хүндрэл бэрхшээл дарамт үргэлжилнэ гэдгийг тодорхой ойлгуулахын тулд бид Европын холбоотон улсуудыг цуглан хуралдуулсан.

Үүний зэрэгцээ бидний эхлүүлсэн нийт 3,4 тэрбум ам.долларын өртөг бүхий Европын аюулгүй байдлыг хангах санаачилга болон НАТО-ийн Польш болон Балтийн улс орнуудад тараан байршуулах шинэ чиглэл хөтөлбөрүүд нь цаашдаа ОХУ-ын зүгээс үзүүлж болох түрэмгийллийн эсрэг манай Европын холбоотон улсуудад хамгаалалт дэмждэг болох болно. Аливаа халдлага түрэмгийлэлд өртөх эрсдэлийг бууруулахын тулд эрчим хүчний хангамжаа төрөлжүүлэх, мөн батлах хамгаалах салбарын төсвөө нэмэгдүүлэх хүрээнд Европын улс орнуудад бид дэмжлэг туслалцаа үзүүлсээр олон жил болжээ. Үүний үр дүнд энэ хүрээнд тодорхой өөрчлөлт дэвшилт гарч буйг бид одоо харж байна. НАТО-г тэлэх бэхжүүлэх, ЕХ-той харилцах түншлэлийн хүрээнд АНУ-ын зүгээс хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараагийн засгийн газар нэмэгдүүлэх шаардлагатай.

Ираны цөмийн хэлэлцээр, цөмийн зэвсгийн Шинэ эхлэл хэлэлцээр зэрэг АНУ-тай ижил үзэл бодол, ашиг сонирхол давхцаж буй асуудлууд дээр бид ОХУ-тай нээлттэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх болно. Вашингтон болоод Москва хоорондын *modus vivendi* (сөргөлдөгч талууд хоорондоо тайван амгалан орших талаар хийсэн жирийн тохиролцоо)-гүйгээр Сирийн дайн хэрхэн дуусахыг төсөөлөхөд хэцүү юм. Цэрэг зэвсгийн шинэ техник технологи нь буруу ойлголт буруу тооцооллын хувийг өсгөдгийн учир өөрсдийн үзэл бодлоо зөв ойлгуулах, стратегийн тогтвортой байдлаа хангахын тулд бидэнд ОХУ-тай тогтвортой, ажил хэргийн холбоо харилцаа хэрэгтэй.

Дэлхийг дотор нь дайсан ба нөхөр гэж ангилах ерөнхий ойлголт байдаг ч яг үнэн хэрэг дээрээ олон улсын харилцаанд биеэр уулзаж учир ч үзээгүй хүмүүстэй хамтран ажиллах хэрэгцээ шаардлага гардаг. Манай засгийн газар Ирантай 30 жилийн турш зөрчилтэй явж ирсэн ч цөмийн зэвсгийг хориглох хэлэлцээрт хүрэх боломж бололцоог эрэлхийлсэн нь ийм учиртай. Тегеран бидний найз ч биш түнш ч биш. Гэсэн хэдий ч хоригийг цуцалж, дэглэм тогтоох гэсэн чин хүсэл эрмэлзэл мөн бидний урилсан Ираныг хэлэлцээрт хүрэхийг шаардсан олон улсын шахалт үр дүнгээ өгсний хамтаар олон улсын аюулгүй байдлын томоохон заналхийлэл болоод байсан Ираны цөмийн зэвсэг эзэмших явдлыг амжилттай үгүй хийж чадсан билээ.

Гэрээ хэлэлцээрийн үр дүнгээ өгч буй нь 1 жилийн дараа тод харагдаж байна. Иран одоогийн байдлаар центрифугийн 23-г устгалд оруулаад байгаа төдийгүй сул баяжуулсан ураныхаа 98 хувийг далайд хаясан бөгөөд Арак дахь плутони реакторын цөмийг устгаж, оронд нь цементээр дүүргэсэн нь олон улсын шинжээчдийг Иран цөмийн зэвсгийн үйлдвэрлэлээ бүр мөсөн орхисон гэдэг дүгнэлтэд хүргэх хэмжээний арга хэмжээг аваад байна. Гэрээгээр Ираныг цөмийн зэвсэг үйлдвэрлэх бүхий л боломж арга замыг хориглосоны зэрэгцээ дэглэм зөв хэмнэлдээ орсон тохиолдолд цаашдаа Тегерантай хамтран ажиллах боломж бололцоог ч мөн тусгасан. Зарим хүмүүсийн санал болгосончлон хэлэлцээрт хүрэлгүй энэ асуудлыг

орхисон бол өөрөөр хэлбэл Ираны цөмийн хөтөлбөрийг зөнд нь орхисон бол Израиль болон хойг дахь манай түнш улсуудад учрах заналхийлэл нэмэгдэж, олон улс АНУ-ын эсрэг чиглэж, дундад азийн нөхцөл байдал өөр нэгэн том дайн үүсэх хурцадмал байдалд хүрэх байсан биз ээ.

Хэлэлцээрийн хэрэгжилтэд шүүмжлэлтэй хандаж буй хэсэгт хэлэхэд энэхүү цөмийн хэлэлцээрийн зорилго нь Тегераны бүхий л асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй гэдгийг санах хэрэгтэй. АНУ-ын зүгээс Ираныг баллистик пуужин ашиглах, терроризмыг дэмжих, хүний эрхийг зөрчсөн эдгээр үйлдлүүдэд нь хариуцлага хүлээлгэхийн тулд тодорхой хориг тавих зэргээр бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан төдийгүй Ираны тогтворгүй үйлдлийн эсрэг холбоотон түнш улс орнуудтайгаа хамтран ажиллаж байна.

### ***Үндэстэн дамнасан сорилтуудыг давах нь***

Хүрээлэн буй орчны доройтол, компьютерийн вирус, өвчин үүсгэгч жижиг организм, хор хөнөөлтэй буруу үзэл суртал зэрэг үндэстэн дамнасан аюул заналхийллүүд хил хязгаар ялгана гэж үгүй билээ. Хуучин цагт ч тусгаарлалт гэдэг зүйл аюулгүй байдал гэх ойлголтын буруу дүгнэлтээс цаашгүй байлаа. Харин одоо бид өөрсдийгөө эдгээр аюулаас хааж хашаад, эсвэл хэн нэгнийг бидний асуудлыг шийдвэрлээд өгнө гээд хүлээж суух боломжгүй цаг үе иржээ. Тоймч сэтгүүлч Томас Фредманы нэгэнтээ хэлсэнчлэн “Та муу хөршийндөө зочлохгүй бол тэр тань дээр зочлон ирнэ”.

Жинхэнэ аюулгүй байдал гэдэг хил дамнасан өргөн хүрээний шийдэлд оршино гэдгийг бид 2014 онд Баруун Африкт гарсан эбола өвчний тархалтаас ойлгож авсан. Аймшигт өвчинтэй нүүр тулахад бид аяллыг хориг тавих зэргээр зүгээр л нэг хорио тусгаарлалтыг урилах биш харин шинжлэх ухааны шийдлийг хайсан юм. Бид цэрэг хүчнээс эрүүл мэндийн үйлчилгээ, салбарын мэргэжилтнүүдийн боловсрол хөгжилд анхаарах зэргээр бүх хүчээ дайчилсан. Уйгагүй үйл ажиллагааны үр дүнд бид нөхцөл байдалд тохирсон яаралтай тусламжийг үзүүлж хэдэн мянган хүний амийг аварч чадсан.

Эболагаас гадна, ДОХ, БЗХӨ-тэй тэмцэх, Африкийн хүүхэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, чичрэг өвчний эсрэг томоохон хөрөнгө оруулалт хийж шинэ түншлэлийн ажиллагааг эхлүүлсэн. 2014 онд манай засгийн үед эхлүүлсэн, дэлхийн 50 гаруй улс орныг өөртөө нэгтгэсэн “Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлын төсөл хөтөлбөр”-ийн хүрээнд ирээдүйд гарч болох асуудал аюулаас хамгаалахын тулд Африк болоод дэлхий дахин дахь эмзэг бүлгийн улс орнуудыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. АНУ-Африкийн удирдагчдын дээд хэмжээний уулзалт, Африкийн залуу удирдагчдын санаачилга” зэрэг форумар дамжуулан энэхүү бүс нутгийн цаашдын гэрэлт ирээдүйд хувь нэмрээ оруулах иргэний нийгмээс дээд шийдвэр гаргах түвшний бүхий л удирдагчидтай цаашдын түншлэлийн харилцааг хөгжүүлэх өргөжүүлэхэд хамтран ажиллах хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Америкийн манлайлал мөн цаг уурын өөрчлөлтийн асуудалд тодорхой шийдвэрлэх үр дүнгээ өгсөн. Манай засгийн үед гаргасан хөрөнгө оруулалтын үр дүнд АНУ салхинаас гаргаж авах цахилгаан эрчим хүчний хэмжээ 3 дахин өсч, 2008 оноос хойш нарны эрчим хүч 20 дахин нэмэгджээ. Бид 2025 он гэхэд машины шатахуун хэмнэлтийг 2 дахин нэмэгдүүлэх тухай журмыг хуулинд тусгасан төдийгүй цахилгаан станцаас ялгаруулж буй нүүрсхүчлийн хийг бууруулах төлөвлөгөө боловсруулаад байна. Эдгээр нь дэлхийн дулааралтай тэмцэхэд дотооддоо гаргасан АНУ-ын томоохон алхмуудын нэг бөгөөд бидний хийж хэрэгжүүлж байгаа алхам бид энэхүү аюулыг ямар нухацтай түвшинд авч үзэж байгааг нотолхын зэрэгцээ дэлхийн бохирдлын хамгийн их хувийг ялгаруулдаг Хятад улсаас эхлээд дэлхийн бусад улс орныг энэ асуудалд чиглэсэн дорвитой алхам хийхийг уриалж буй хэрэг юм.

Түүнчлэн цаг агаарын өөрчлөлтөд өртөж буй дотоодын болоод дэлхийн даяар тархан суурьшсан тэдгээр хүмүүсд энэхүү өөрчлөлтөнд дасан зохицох чадварыг сайжруулах тал дээр бид ажиллаж байна. Эргийн дагуу амьдардаг хүмүүст учрах үерийн эрсдэлийг тооцоолох, мөн урт хугацааны ган гачигт нүүрлэсэн тохиолдолд хэрхэн бэлтгэлтэй байх үндэсний ойлголтыг сайжруулахад чиглэсэн стратеги боловсруулж байна. Мөн бид дэлхий дахинд тогтвортой хөгжлийг хангах хүрээнд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллаж буйн нэгэн жишээ нь цаг уурт тулгуурласан ухаалаг хөдөө аж ауйг дэмжсэн “Feed the Future” “хэмээх тусламжийн хөтөлбөрийг дурьдаж болох юм. Бидний 3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн НҮБ-ын Ногоон цаг уур сан нь эмзэг ядуу улс орнуудыг цаг уурын өөрчлөлтөд бага өртөх дасан зохицоход туслах зорилготой. “Power Africa” санаачилгын хүрээнд энэхүү бүс нутагт цэвэр тогтвортой арга барилд суурилсан цахилгаан эрчим хүчээр хангах зорилго тавин ажиллаж байна.

Энэ бүх хүчин чармайлт төсөл санаачилга нь бидний өөрсдийн гариг ертөнцөө хамгаалах гэсэн зорилгод үндэслэсэн юм. Гэхдээ дараагийн шинэ ерөнхийлөгч шинжлэх ухааны салбарыг ашиглаж, юу ч хийхгүй хойш суухын аюулыг таньж мэдсэн, аюул заналхийллийг шийдвэрлэхийг улс төрийн зорилгоо гэж харсан тохиолдолд л цаашдын үр дүн боломж бололцоо тодрон гарах болно.

Үндэстэн дамнасан аюулын нэг тод жишээ бол товчлууур дарахад л үүсэх аюулууд үүнд худалдааны юм уу, засгийн газрын мэдээ баримтыг хулгайлах гэсэн улс төрийн шинжтэй тоглогчид ч байж мэднэ. Эсвэл Америкийн компаний эсрэг цахим дайралт хийж буй Хойд Солонгос, Италийн эсвэл нэр нь үл мэдэгдэх хакер ч байж болно. Тиймээс бид цахим хамгаалалтаа бэхжүүлж, хувийн хэвшлийнхэн болоод төрийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээгээ өргөжүүлж, хакерчдад хориг тавих эрхийг Сангийн яаманд олгож, кибер халдлагаас хамгаалах, түүнээс гарахад өөрсдийн чадвар чадамжаа дээшлүүлэх тал дээр ажилласан.

Мөн бид худалдааны ашиг олох зорилгоор цахим орчимд эдийн засгийн тагнуулын үйл ажиллагаа явуулахгүй байх хэлэлцээр хийсэн зэргээр хятадын цахим ертөнц дахь хэд хэдэн чухал үйл ажиллагаагаанаас хамгаалж чадсан

бөгөөд манай энэхүү жишгийг өөр хэд хэдэн улс авч хэрэгжүүлсэн. Бид иргэний нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөдөлгүүр болсон нээлттэй, тодорхой, зохимжит интернет хэрэглээг дэмжсээр байх олно. Эцэст нь бид энх цагийн хариуцлагатай, сайн дурын үйл ажиллагааны хэм хэмжээг ухамсарласан үзэл бодол нэгтэй улс орнуудын холбоог бүтээхийн зэрэгцээ G-7, G-20-д багтдаг томоохон улс орнуудын удирдагчдын баталгаажуулсан цахим орчны тогтвортой байдлыг хангахад чухал хүчин чармайлт гаргаж байна. Дараагийн засаг энэхүү буухиаг үргэлжлүүлж, дараагийн арван жилд өрнөх өрсөлдөөн худалдааг тодорхойлох шийдвэрлэх домайны болон далайн сансрын шинэ дүрмийг тогтоох оролдлогын нэг хэсэг болсон дижитал хувьсгалын зарчмыг цаашдаа боловсронгуй болгох хэрэгтэй.

### ***Хэт даврагч бүлэглэлийг дарах***

Терроризм, хэт даврагсад бол АНУ-ын манлайлал шаардлагатай гэж үзэх үндэстэн дамнасан аюулын хамгийн тод жишээ юм. Аль Кайда, ISIS зэрэг бүлэглэлийн үйл ажиллагааны үр дагавар нь жинхэнэ аюулыг бий болгодог бөгөөд Парис, Брюссель, Орландо, Истанбул зэрэг дэлхийн томоохон хотуудад болсон халдлагууд бид бүхэнд хаана ч терроризм гарч болно гэдгийг дахин дахин сануулсаар байна. Гэхдээ айдас хүйдэс эргэлзээ тээнэгэлзээн дунд ч бид террористууд АНУ болоод бидний бүтээсэн соёл иргэншлийг үгүй хийж чадахгүй гэдгийг санах ёстой. Мөн бид хэзээ ч Америкийн ард түмний хүч чадлыг дутуу үнэлж болохгүй.

Терроризмийг бид заавал ялах ёстой ялах ч болно. Афганистан, Иракттай дайтсан арав гаран жилийн дайн бидэнд энэхүү аюулыг давахын тулд хэзээ хэрхэн цэргийн хүчээ ашиглах тухай хэцүү боловч ухаарууштай зарим нэгэн хичээлийг заасан. Афганистан, Иракийн дайнаас 165,000 цэргээ гаргаж байхдаа ч Ерөнхийлөгч Обама Америкийн ард түмнийг хамгаалахын тулд шаардлагатай гэж үзвэл энэ хүчээ ашиглахаас буцахгүй байсан. Энэ тухай Осама бин Ладенгаас, Афганистан Пакистанд амжилттай үйл ажиллагаа явуулсан Аль Кайда бүлэглэлийн дайчдаас, Сомали Иемен дахь Аль Кайда бүлгийн удирдагчдаас, ISIS-ын 120 гаруй удирдагч гүйцэтгэгчдээс асуухад л хангалттай. Бид өөрсдийн хүчээ ашиглахдаа гарах үр дүн, үй олон хүний амь насны асуудлыг тооцоолж маш нарийн няхуур ханддаг. Хэрвээ хүчээ ашиглалаа гэхэд заавал ашигтай үр дүн гарах ёстой. АНУ-ын ашиг сонирхолд суурилсан тодорхой даалгавар дор бид нарийн, пропорционал цэргийн үйл ажиллагаа явуулдаг. Боломжтой бол даалгаврыг амжилттай биелүүлэхэд холбоотон түнштэйгээ хамтран ажилладаг.

Хэрвээ АНУ-ын цэргийн оролцоо улс төрийн хөгжил болоод нутгийн иргэдийн өөрсдийн газар нутгаа удирдах чадамжийг бүрдүүлж чадахгүй аваас тулаанд гаргасан амжилт үр дүнгээ өгөхгүй гэдгийг бид ойлгож авсан юм. Аль Кайда болон ISIS-ын эсрэг цаашдаа үргэлжлүүлэн ялалт байгуулах үйл хэрэгт нутгийн хүмүүсээс бүрдсэн хүчний оролцоо шаардагдах бөгөөд ингэснээр тарж бутарсан сууринг буцааж нэгтгэх, тухайн чөлөөлөгдсөн бүсийн засаглалыг үр ашигтай удирдан явуулах болно. Тиймээс бид Аль Кайда болон бусад террористуудыг



буулган авах Афганы хүчийг бэлтгэхийн тулд ойролцоогоор 30 гаран үндэстэнтэй хамтран ажиллаад байна. Иймээс бид Аль Кайда болон ISIS-н салбаруудыг буулган авахын тулд Ливи, Нигери, Сомали, Тунис зэрэг улсын засгийн газруудтай хамтран ажиллах түншлэл тогтооход их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн юм. Одоогоор Иран, Иракт нутгийн цэргийн хүчнийг бэлтгэх нийт 66 гишүүн холбоог байгуулаад байгаа бөгөөд дайнд нэрвэгдсэн ард иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлсээр байна. Манай тусгай ажиллагааны баг бүрэлдэхүүн байрлан ажиллаж байгаа төдийгүй 2016 оны 7-р сарын байдлаар нутгийн явган цэргийн хүчинд тусламж үзүүлэх зорилгоор 13000 удаа агаараас цохилт өгсөн мэдээ баримт бий. Тагнуул болоод хууль хэрэгжүүлэгч албаны мэдээлэл солилцох, мэдээллээр хангах хамтын ажиллагааны тусламжтайгаар бид түншлэгч улс орнуудтайгаа тэдгээрийн хилийн аюулгүй байдлыг сайжруулах, Ирак Сири дэх гадаадын дайчдын урсгалыг 50 хувиар бууруулах, ISIS-н санхүүгийн эх үүсвэрийг хаах зэрэг асуудлууд дээр хамтран ажиллаж байна. Үр дүнд ISIS-н хүч саарч байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд энэхүү бүлэглэл баруун Иракаас зүүн Сири хүртэлх газрыг бүслэлтэд аваад байсан бөгөөд Иракт нэгэнтээ эрх мэдэлдээ оруулаад байсан газрынхаа 50 хувийг, Сири дэх газрынхаа 20 гаруй хувийг алдаад байна. Бид ISIS-н тэргүүн салааны хэдэн мянган дайчдыг устгасан бөгөөд одоо ISIS хүн хүчнийхээ 1/4-ийг алдаад байна. Тэдний нэр цуу огцом унаж нутгийн иргэдийг хараандаа байлгах хүч нь суларсаар байна. Мөн бид олон улстай хамтран Иран Ирак дахь дайнд нэрвэгдэн орон гэргүй үймээн самуунд автсан ард иргэд болон дүрвэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд хэдэн тэрбум ам.долларын хөрөнгө гаргах тал дээр ажиллаж байгаа бөгөөд ISIS-ээс чөлөөлөгдсөн бүсийг сэргээн босгох, нөхцөл байдлыг тогтворжуулахад үүнээс ч их мөнгө зарцуулж байна. Сирид улс төрийн шилжилт хийхийн тулд бид дипломат арга барилыг шургуу ашиглаж байна. Учир нь зөрчил мөргөлдөөнийг цэрэг зэвсгийн аргаар шийдвэрлэж болохгүй мөн Башар Аль Асадын засгийн эрх тогтож байгаа нөхцөлд дайн тийм хурдан дуусна гэж байхгүй. 2014 онд Арабын зүрхэнд Халифын нэгдсэн улсыг байгуулах гэсэн хэсэг бүлэг хүмүүсийн оролдого нь ISIS-г анх бий болгосон гэдгийг энд дахин сануулмаар байна.

Исламын улс бүлэглэл буюу ISIS (Islamic State of Iraq and Syria) Халифын хаант улс байгуулах гэсэн санаархал нуран үгүй болсон ч жихадын сорилт үргэлжлэх болно. Жихадын бусад түрэмгий хөдөлгөөнүүд гол түлхүүр улсуудын засаглал тогтоогүй орон зайг ашиглаж тогтвортой байдалд аюул заналхийлэл учруулсаар байх болно. Боко Харам бүлэглэл олон жилийн өмнө Нигерид аюул заналхийлэл болж байсан ба өөрсдийгөө Баруун Африкийн Исламын улс хэмээн нэрийдэж байлаа. Энэ мэт бүлэглэлийг үндэс болсон Салафийн жихадист үзэлд бол Сан Бернардино, Орландо Ницэд болсон шиг халдлага үйлдэх ганцаар ажилладаг террористууд шаардлагагүй. Харин дээрх бүлэглэлд байлдаж яваад нутаг буцсан гадаадын дайчид л Парис, Брюссельд болсон шиг халдлага үйлдэх оролдлого гаргаж магад. Дараагийн засаг үргэлжлүүлэн ухаалаг, ул суурьтай, цогц арга барилаар энэхүү асуудалд хандах шаардлагатай болох нь. Үүнийг

хэрэгжүүлэхэд манай тагнуул хууль сахиулахын ажилчид мэргэжлийн хүмүүсийн хүчин чармайлтын хамтаар цэргийн хүчний мэргэжлийн үүрэг даалгавар хэрэг болох нь дамжиггүй. Мөн тогтворгүй эмзэг нөхцөл байдалд байгаа улс орнуудын засаглалыг сайжруулахад олон улсын хамтын нийгэмлэг болон нутгийн түншүүдтэй хамтран ажиллах хэрэгтэй болно. Гэхдээ дийлэнх хувь нь Салафийн жихадистын үзэл суртлыг эсэргүүцдэг дэлхий дээрх 1.5 тэрбум Мусульмануудыг өөрийн талд үлдээх мөн бидний үнэт зүйлд нийцсэн арга барилаар хэт даврагсдын эсрэг энэхүү цогц кампанит ажил явуулсан тохиолдолд л энэхүү үйл ажиллагаа амжилттай хэрэгжлээ гэж үзэж болох юм. Өнгөрсөн жил ISIS-н гол удирдагч Абу өөрийн бүлэглэлийн үйлдсэн халдлагын зорилгыг тайлж хэлэхдээ: Загалмайтны дайчдыг өөрөө өөрсдийгөө хөнөөхийг албадах. Баруун дахь Мусульмануудын өмнө хоёр сонголт байна нэг бол шашнаасаа татгалзах үгүй бол Исламын улсад шилжиж ирэх ингэснээр залхаан цээрлүүлэлтээс мултрана гэжээ. Бид энэ мэт бүлэглэлүүдэд тэдний хүсээд байгаа шашны дайн эхлүүлэх боломжийг хэзээч өгч болохгүй. Энэ нь зөвхөн бидэнд үнэт зүйлдээ тууштай байх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд, дайсныхаа тактикийг бут цохих хүч болох учиртай. Үгүй бол энэ нь бидний баримталдаг үнэт зүйлийг зөрчөөд зогсохгүй манай улсын аюулгүй байдалд ноцтой хохирол учруулна.

### ***Тогтвортой хөтөлбөр***

Дараагийн засгийн газарт шийдэх асуудал тун их байх нь: Бөмбөрцгийн баруун хэсгийг нэгтгэх, Ази дахь манай түнш холбоотон улсуудтай харилцах харилцаагаа өргөжүүлэх, бүс нутгийн их гүрнүүдтэй иж бүрэн харилцаа холбоотой байх, цаг уурын өөрчлөлт терроризм зэрэг үндэстэн дамнасан хурцадмал асуудлуудад анхаарлаа хандуулах. Гэхдээ Америкийн ард түмний цуцашгүй эрч хүч мятаршгүй чанар мөн бидний хийж хэрэгжүүлсэн ажил хэргийн үр дүнд олон улсын энх тайван хөгжил цэцэглэлтэд манай улс орон манлайлан оролцох чадамж бий гэдэгт миний бие урьд урьдаас илүү итгэл дүүрэн байна. Өнөөдрийн Америкийн жанжлал зүгээр нэг Америк ид шидээс үүсээгүй юм шүү гэдгийг энд цохон тэмдэглэе. Харин бид энэхүү байр суурийг урт удаан хугацааны шаргуу хичээл хөдөлмөр, сахилга бат, мөнхүү хариу золиосоор олж авсан юм. АНУ-ыг энэхүү байр сууринаас татан унагаах үй олон дэнчин бий. Өнөөдөр бидний гаргах шийдвэр манай гарагийн ирээдүйг жолоодно. Томоохон сорилт, гайхалтай боломж бололцоо бүхий энэ цаг үед дэлхий дахинд АНУ-ын тогтвортой жанжлал юу юунаас илүү хэрэгтэй байна

Энэхүү нийтлэлийн эх хувийг дараах холбоосоор орж үзнэ үү.

<https://www.foreignaffairs.com/articles/united-states/2016-08-07/building-success>